

**“СҮҮ” ХК**  
**ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРАЛ**

2014 оны 4 дүгээр сарын 30-ны өдөр

**Хувьцааны мэдээлэл:**

Нийт хувьцааны ширхэг- 344,000 ширхэг  
Зах зээлийн үнэлгээ- 36.12 тэрбум төгрөг  
Хаалтын ханш (4/30/2014): 105,000 төгрөг  
Хувьцааны төвлөрөл: 93.81% (3 хувьцаа эзэмшигч, 322,723 ширхэг)  
Хувьцаа эзэмшигчдийн тоо: 277  
Хувьцааны дансны үнэ: 51,027 төгрөг

**Хувьцаа эзэмшигчдийн хурлын мэдээлэл:**

“Сүү” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хуралд 55.7% буюу 191,608 ширхэг хувьцаа эзэмшигч 3 хүний ирцтэйгээр хуралдав. Хурлаар хэлэлцсэн асуудал:

- Компанийн 2013 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар гаргасан ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэж батлах,
- Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг чөлөөлж, томилох асуудлыг хэлэлцэж батлах,
- 2014 онд ногдол ашиг хуваарилахгүй байх тухай ТУЗ-ийн шийдвэрийг танилцуулах,

Тус хуралд Гүйцэтгэх захирал Б.Гантулга, ТУЗ-ийн дарга Д.Ганбаатар, үйлдвэр хариуцсан захирал Энхтуяа болон бусад албаны дарга нар оролцсон болно.

**Хэлэлцсэн асуудал 1:**

“Сүү” ХК-ийн сүү бэлтгэлийн хэмжээ өмнөх оноос 25%-иар өсөж 13.7 сая литр сүү бэлтгэсэн бөгөөд энэ нь түүхэн дахь хамгийн их сүү бэлтгэсэн жил болсон байна. Ингэснээр нийт 18,439 тн бүтээгдэхүүн үйлдвэрлэж борлуулалтын орлого нь 34.07 тэрбум төгрөгт хүрчээ.

Нийт борлуулалтын орлогын 45.6% буюу 15.5 тэрбум төгрөг нь сүүнээс, 45.2% буюу 15.4 тэрбум төгрөг нь тарагнаас, үлдэх 3.09 тэрбум нь бусад бүтээгдэхүүнээс олсон орлого байна.

2013 оны төлөвлөгөөг 101.9%-ийн биелэлтэйгээр давуулсан ба энэ нь 2012 оноос биет хэмжээгээр 10%, мөнгөн дүнгээр 32.2% өссөн дүн болжээ.

Борлуулалт ингэж өсөх болсон шалтгаан нь бүтээгдэхүүний өртөгтэй холбогдуулан бүтээгдэхүүний үнээ нэмэгдүүлсэн мөн ШБӨХЗГ-аас сүүн бүтээгдэхүүн дээр сүүний гарал үүслийг зааж өгөх шийдвэр гарсан нь “Сүү” ХК-ийн сүүний борлуулалтанд эерэг нөлөө үзүүлжээ. Энэ нь “Сүү” ХК-ийн сүүг бусад хуурай сүүнээс ялгаж өгсөн хэрэг болсон байна. 2013 онд бүтээгдэхүүний нэр төрөлд тарагний ундааны 3 төрөл нэмсэн байна.

Борлуулалтын орлого 34% нэмэгдсэн ч цэвэр ашиг 3.6%-иар өсөж 2.6 тэрбум төгрөг болсон. Энэ нь тус компани 2011 онд IFC-гээс 6 сая ам.долларын зээл авсан бөгөөд ханшийн зөрүүний алдагдал 2.3 тэрбум төгрөг болсоноос үүдэн цэвэр ашгийн үзүүлэлтэд сөргөөр нөлөөлсөн байна.

Компанийн 2013 оны жилийн эцсийн байдлаар 18.9 тэрбум төгрөгийн өр төлбөртэй байгаа ба үүнийг дийлэнх хэсэг нь IFC-ийн зээл, үлдэх хэсэг нь дотоодын банкуудын зээл байна. Энэхүү IFC-ийн ам.дол-ын зээлийг төгрөгийн зээл рүү шилжүүлэх талаар банкуудтай яриж байгаа бөгөөд одоогийн байдлаар EBRD-д хүсэлтэй өгөөд байна гэлээ.

**Компанийн зүгээс өр төлбөрөө барагдуулах, бусад хөрөнгө оруулалтаа шийдвэрлэх талаар нэмэлт хувьцаа гаргах бодолтой эсэхийг асуухад ТУЗ-ийн хэмжээнд одоо яригдаж байгаа, шийд гарвал эргэж мэдэгдэхээр боллоо.**

Зэрэгцүүлсэн баланс /сая төгрөгөөр/

Он	2012	2013
Хөрөнгө		
Эргэлтийн хөрөнгө		
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	294.50	584.18
Дансны авлага	4,243.28	7,276.07
Бараа материал	6,190.63	5,960.11
Урьдчилж төлсөн төлбөр	4,787.06	6,503.39
Нийт эргэлтийн хөрөнгө	15,515.46	20,323.75
Эргэлтийн бус хөрөнгө		
Үндсэн хөрөнгө	16,272.00	20,475.45
Бусад үндсэн хөрөнгө	931.61	1,344.74
Нийт үндсэн хөрөнгө	17,203.61	21,820.19
Хуримтлагдсан элэгдэл	(3,795.91)	(5,389.53)
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	13,407.69	16,430.67
<b>Нийт хөрөнгийн дүн</b>	<b>28,923.15</b>	<b>36,754.42</b>
Өр төлбөр ба эздийн өмч		
Эргэлтийн эх үүсвэр		
Дансны өглөг	1,203.84	1,422.26
Цалингийн өглөг	63.80	97.39
Татварын өглөг	55.77	150.88
Банкны богино хугацаат өглөг	2,875.22	5,255.09
Богино хугацаат өглөгийн дүн	4,198.63	6,925.62
Урт хугацаат өр төлбөрийн дүн	8,832.60	11,995.47
<b>Нийт өр төлбөрийн дүн</b>	<b>13,031.23</b>	<b>18,921.09</b>
Эздийн өмч		
Хувьцаат капитал	28.12	28.12
Хуримтлагдсан ашиг	12,194.24	14,135.64
Бусад	3,669.57	3,669.57
Эздийн өмчийн дүн	15,891.92	17,833.32
<b>Өр төлбөр ба эздийн өмчийн дүн</b>	<b>28,923.15</b>	<b>36,754.42</b>

## Зэрэгцүүлсэн орлогын тайлан /сая төгрөгөөр/

Санхүүгийн үзүүлэлт	2012 он	2013 он	2013 оны өсөлт
<b>Борлуулалтын орлого</b>	<b>25,083</b>	<b>33,822</b>	<b>34.8%</b>
Борлуулалтын хорогдол, буцаалт	155	260	67.4%
Борлуулалтын хөнгөлөлт	47	53	12.6%
<b>Цэвэр борлуулалтын орлого</b>	<b>24,880</b>	<b>33,509</b>	<b>34.7%</b>
Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	17,918	23,004	28.4%
<b>Нийт ашиг</b>	<b>6,962</b>	<b>10,504</b>	<b>50.9%</b>
Үйл ажиллагааны зардал	3,757	4,926	31.1%
<b>Үйл ажиллагааны ашиг</b>	<b>3,206</b>	<b>5,578</b>	<b>74.0%</b>
Үндсэн бус үйл ажиллагааны ашиг алдагдлын дүн	(334)	(2,237)	569.0%
Татвар төлөхийн өмнөх ашиг алдагдал	2,871	3,341	16.4%
Орлогын татварын зардал	340	718	111.5%
<b>Татварын дараах цэвэр ашиг</b>	<b>2,532</b>	<b>2,623</b>	<b>3.6%</b>

**Хэлэлцсэн асуудал 2:**

Компанийн гүйцэтгэх захирал солигдож 2014 оны 1 сарын 1-нээс Б.Гантулга ажиллаж эхэлж буй бөгөөд үүнтэй холбогдуулан өмнөх ТУЗ-ийн гишүүн Д.Мөнхжаргал-ыг ТУЗ-ийн гишүүнээс чөлөөлж оронд нь Б.Гантулга-ыг томиллоо.

Б.Гантулга нь 2004 оноос ажлын гараагаа эхлэсэн бөгөөд Хас Банк, Моннис Групп, Роял Дойч зэрэг байгууллагуудад мэргэжилтэн, маркетингийн албаны дарга, дэд захирал, гүйцэтгэх захирал зэрэг албуудыг хашиж байсан туршлагатай байна

ТУЗ-ийн гишүүдийн жагсаалт

1. Д.Ганбаатар –ТУЗ-ийн дарга /гол хувьцаа эзэмшигч/
2. Д.Уянгалянхуа
3. Б.Түвшинтөгс /гол хувьцаа эзэмшигч/
4. Н.Бадамханд
5. Д.Цэрэнжигмэд
6. **Б.Гантулга – CEO**
7. Ц.Соёл-эрдэнэ
8. Д.Жамьяан /гол хувьцаа эзэмшигч/
9. Г.Баяр
10. Ш.Даваалимбэ
11. Н.Цэрэндорж
12. П.Мэндсайхан

**Хэлэлцсэн асуудал 3:**

2011 онд IFC-гээс зээл олгохдоо тавьсан шаардлагуудын нэг нь зээлээ төлж дуустал компани ногдол ашиг тараахгүй байхыг шаардсан бөгөөд үүний хүрээнд 2011 оны ТУЗ-ийн хурлаас 2019 оны хүртэл ногдол ашиг тараахгүй тухай шийдвэр гаргажээ. Үүнийгээ жил бүрийн ХЭХ-аар танилцуулж байгаа юм байна.

Хэрэв уг зээлийг хугацаанаас нь өмнө суллавал ногдол ашиг тараах тухай дахин ТУЗ-ийн хурлаараа авч хэлэлцэх юм байна.

Мэдээлэл бэлтгэсэн: Ц.Цог